Гэмтэл согог судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2021 оны А/162 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Гэмтэл согог судлалын үндэсний төв нь 2021 онд “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам” батлуулж Ерөнхий захирлын 2021 оны 5 дугаар сарын 10-ны А/65, 9 дүгээр сарын 1-ний А/112 дугаар тушаалуудаар дотоод хяналт шалгалтын удирдамж батлагдсан боловч хяналт шалгалт хийгдсэн эсэх нь тодорхойгүй байна.

2021 оны 9 дүгээр сарын 9-нөөс 9 дүгээр сарын 20-ны хооронд Эрүүл мэндийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2020 оны санхүү, аж ахуйн зарим үйл ажиллагаанд хэсэгчилсэн санхүүгийн хяналт, шалгалт, дотоод аудитыг 2 хүний бүрэлдэхүүнтэй хийж, шалгалтын тэмдэглэл үйлдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Шалгагдагч байгууллага төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-т заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 36,622,472.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 366,224.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 256,357.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар тооцоход 422,781.6 мянган төгрөг болж байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,340,223.3 мянган төгрөгөөр буюу 31.3 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн

хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,000.0	69,205.5	67,205.5
Авлага	48,139.7	5,959,830.7	5,911,691.0
Бараа материал	1,633,460.1	2,116,928.6	483,468.4
Үндсэн хөрөнгө	28,160,869.2	31,038,727.6	2,877,858.3
Нийт хөрөнгө	29,844,469.1	39,184,692.4	9,340,223.3
Өр төлбөр	7,538.4	1,938,030.3	1,930,492.9
Засгийн газрын хувь оролцоо	29,836,931.7	37,246,662.1	7,409,730.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	29,844,469.2	39,184,692.4	9,340,223.3

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 67,205.5 мянган төгрөгөөр өссөн;
- Авлага данс 5,911,691.0 мянган төгрөгөөр өссөн нь ЭМД-ын сангаас авах 5,919,830.7 мянган төгрөгийн авлага үүссэн;
- Үндсэн хөрөнгө 2,877,858.3 мянган төгрөгөөр өссөн иргэнээс хандивласан 12,000.0 мянган төгрөгийн тусгай зориулалтын автомашин, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй төслийн хүрээнд 162,736.3 мянган төгрөгийн эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмж, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар 6,297,469.5 мянган төгрөгийн эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмж, 37,500.0 мянган төгрөгийн автомашин, ТӨБЗГ-ын 2021 оны А-1/2186 тоот албан тоотыг үндэслэн, ЭМЯ-наас 37,500.0 мянган төгрөгийн балансын үнэтэй, 12,500.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй автомашиныг балансаас балансад шилжүүлэн авсан, төсвийн хөрөнгөөр 219,793.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил, компьютер техник хэрэгсэл, эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийг худалдан авсан;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 1,930,492.9 мянган төгрөгөөр өссөн нь ЭМД-ын сангийн санхүүжилт дутуу орж ирснээс НДШ-ийн өглөг 182,738.6 мянган, татварын өглөг 115,181.8 мянган, эм, эмнэлгийн хэрэгслийн 1,555,824.3 мянган төгрөгийн өглөгтэй гарсан;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 37,246,662.1 мянган төгрөг болж, 7,409,730.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээр нэмэгдүүлэн тайлагнасантай тус тус холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлтүүд:

Нийт орлого өмнөх оноос 4,503,398.6 мянган төгрөгөөр буюу 10.0 хувиар, үүнээс Эрүүл даатгалын сангийн санхүүжилт 18,488,755.9 мянган төгрөгөөр буюу 92.1 хувиар, нэмэлт санхүүжилтийн орлого 1,481,459.9 мянган төгрөгөөр буюу 7.5 дахин өссөн, бол үндсэн үйл ажиллагааны орлого 2,631,675.9 мянган төгрөгөөр буюу 56.8 хувиар буурсан байна.

ЭМД-ын сангийн санхүүжилтийг 2021 оны 3 дугаар сарын 1-нээс эхлэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр тооцож олгох болсон бөгөөд хэвтэн эмчлүүлэх болон өндөр өртөгт тусламж үйлчилгээ, амбулаторийн тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээний тусламж үйлчилгээг тус тус багцлан санхүүжүүлж байгаагаас үйлчлүүлэгчийн тоо буурсан ч санхүүжилт өссөн дүнтэй байна.

Харин “Ковид-19” цар тахалтай холбоотойгоор төлөвлөгөөт хагалгааны тоо болон тусламж үйлчилгээний зардлын төлбөр төлөх тариф өөрчлөгдсөнөөс хамтын төлбөр хэлбэрээр хувь хүний төлөх төлбөрийн хэмжээ тус тус буурсан нь ажиллагааны орлогод нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 4,500,008.0 мянган төгрөгөөр буюу 11.9 хувиар, үүнээс үйл ажиллагааны зардал 5,552,699.1 мянган төгрөгөөр буюу 15.1 хувиар өссөн байна.

Урсгал төсвөөс барилгын засварт 236,068.8 мянган, агааржуулалтын системийн засварт 37,688.6 мянган, эмнэлгийн тоног төхөөрөмжийн засварт 440,907.8 мянган, бусад тоног

төхөөрөмжийн засварт 2,606.1 мянган, тээврийн хэрэглэлийн засварт 22,242.8 мянган, лифтний засварт 4,400.0 мянган, нийт 744,114.1 мянган төгрөг зарцуулжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвийн 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийг 49,701,965.5 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 49,701,965.5 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Дээд шатны төсвийн захирагч төсвийг 13,112,500.5 мянган төгрөгөөр бууруулан, 36,589,465.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Эрүүл мэндийн сайд 2021 оны 12 дугаар сарын 6-ны өдөр төсөвт тодотгол оруулж санхүүжилтийн эх үүсвэрийг 694,086.9 мянган төгрөгөөр бууруулж, 35,895,378.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээнд санхүүжүүлэх 3,239,194.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 95,662.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 32,560,521.7 мянган төгрөгийг ЭМД-ын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,960,579.5 мянган, туслах үйл ажиллагааны орлогоос 161,475,088.1 мянган, ЭМД-ын сангийн санхүүжилтээр 32,639,746.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 34,716,903.8 мянган төгрөгийг зарцуулж, 47,087 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй гарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 96.7 хувьтай байгаа нь цалин хөлсний зардал 285,774.8 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 13,844.8 мянган, нормативт зардлыг 843,168.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас голлон шалтгаалсан байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл.

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	35,895,378.1	34,716,903.8	1,178,474.3	96.7
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	35,895,378.1	34,716,903.8	1,178,474.3	96.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 онд нэмэлт санхүүжилтийн дансанд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 4 төсөл, Эрүүл мэндийг дэмжих сангаас 3 төсөл, Эрүүл мэндийн яамнаас 4 удаагийн буцалтгүй тусламж, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс резидент эмч нарын цалин, сургалтын төлбөрийн нийт 1,717,798.4 мянган төгрөг төвлөрснөөс 1,695,679.9 мянган төгрөгийн зарцуулалт хийгдэж, 22,118.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс Эрүүл мэндийн яамнаас ирсэн нэг удаагийн буцалтгүй тусламжийн 11,200.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс санхүүжүүлсэн сувилахуйн сургалтын төлбөрийн 4,560.0 мянган төгрөг, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн төрөлжсөн, дээшлүүлэх сургалтын төлбөрийн 6,358.5 мянган төгрөгийн тус тус үлдэгдэлтэй гарчээ.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилт нь хүчирхийлэл, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, бууруулах чиглэлээр сургалтууд зохион байгуулахад зориулагдсан бөгөөд сургалтын үр дүнд нийт осол гэмтэл 2 хувиар, хүүхдийн осол гэмтэл 4.1 хувиар, гэр бүлийн хүчирхийлэл 17.5 хувиар, хүүхдийн эсрэг хүчирхийлэл 1.9 хувиар буурсан гэсэн статистик мэдээ гарсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг:

Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, эрүүл мэндийн байгууллагуудын даатгалын сангаас төлөх зардлын төлбөрийг тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр тооцож, 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгох болсон байна.

ЭМДҮЗ-ийн 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар тогтоолоор ЭМДС-аас санхүүжүүлэх оношийн хамааралтай бүлгийн болон хувь хүний хамтын төлбөрийн хэмжээг баталсан.

Хэвтэн болон өндөр өртөгт тусламж үйлчилгээ, амбулаторийн тусламж үйлчилгээ болон оношилгоо шинжилгээний тусламж үйлчилгээг тус тус багцлан санхүүжүүлж байгаагаас ЭМДС-аас авах санхүүжилт өсөж, харин хамтын төлбөр хэлбэрээр хувь хүний төлөх төлбөрийн хэмжээ буурсан байна.

ЭМД-ын сангаас 39,289,792.4 мянган төгрөгийг нэхэмжилснээс хяналтаар 730,310.2 мянган төгрөг хасагдаж, 32,639,746.2 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж, 5,919,735.9 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

Нэхэмжлэх болон гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зөрүү 730,310.2 мянган төгрөг нь ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолын заалтуудтай холбоотой байна. Тогтоолд зааснаар нийт тусламж үйлчилгээг бүртгэсний дараа давхардлыг шалгаж, хасалт хийгддэг байна. Үүнд:

- Амбулаторийн үйлчилгээ аваад, хэвтэн эмчлүүлсэн үед амбулаторийн үзлэгийн санхүүжилтийг олгохгүй гэсэн заалтаар 53,271.0 мянган төгрөг;
- Яаралтай тусламж аваад хэвтэн эмчлүүлсэн тохиолдолд хэвтэхээс өмнөх тусламж үйлчилгээг санхүүжүүлэхгүй гэсэн заалтаар 389,600.0 мянган төгрөг;
- Ерөнхий мэргэжлийн яаралтай тусламж гэж программаар алдаатай бүртгэгдсэн бүртгэлийг засаж, гэмтлийн яаралтай тусламж болгосноос үүссэн зөрүү 10,875.0 мянган төгрөг;
- Эрүүл мэндийн даатгалгүй иргэнд /эмчлүүлэгч даатгалын төлбөрөө эмнэлгээс гарахаас өмнө хийсэн ч программд дутуу төлөлттэй харагддаг/ үзүүлсэн тусламж үйлчилгээг ЭМД-ын сангаас нэхэмжилсэн 194,200.1 мянган төгрөг;
- Яаралтай тусламжаар хэвтэн эмчлүүлсэн, хяналтдаа байлгах шаардлагатай осол гэмтлийн оноштой үйлчлүүлэгчдийг цөөн хоногоор хэвтэн эмчлүүлсэн үед ЭМДҮЗ-ийн ор хоногийн талаарх хяналтын шалгуурыг хангахгүй байна гэсэн шалтгаанаар 82,264.1 мянган төгрөг тус тус хасагдсан байна.

2021 онд тус төвийн тусламж үйлчилгээг сайжруулан, гүйцэтгэлийг нэмэгдүүлж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхийн тулд эмнэлгийн ээлтэй, эрсдэлгүй орчныг бий болгох, үйлчлүүлэгчдийн аюулгүй орчныг бүрдүүлэх, эмч ажиллагсдын ажлын байрны орчныг сайжруулах зорилгоор байрны болон тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг тухай бүр хийж ажиллажээ.

Бусад асуудлын хэсэг:

2021 онд Түлэнхийн төв ашиглалтад ороогүйгээс төсөвлөгдсөн цалин хөлс, ажил ологчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал хэмнэгдсэн байна.

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн газраас 1,824 м.кв газрыг эмнэлгийн зориулалтаар Улаанбаатар бизнес хөгжлийн төв ХХК-д Нийслэлийн Засаг даргын 2010 оны 581 дүгээр захирамжаар хууль зөрчиж олгосон байсныг хүчингүй болгосон тул газрын гэрчилгээ болон

холбогдох бичиг баримтыг шинээр авч, бүртгэлд 40,273.9 мянган төгрөгөөр бусад биет бус хөрөнгөөр тусгасан.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 1 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 96.7 хувийн биелэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Гэмтэл согог судлалын үндэсний төв нь 2021 онд нийт 95,445,394.5 мянган төгрөгийн 175 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу эм, эмнэлгийн хэрэгсэл, өндөр өртөгт мэс заслын хэрэгсэл, аж ахуй, хангамжийн материал, шатахуун, хүнсний материал худалдан авах тендерийг цахимаар нээлттэй, хязгаарлагдмал, харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт хийж, шалгарсан байгууллагуудтай гэрээ байгуулсан байна. Үүнд:

- Аж ахуйн багаж хэрэгсэл, хог хаягдлын уут, аюулгүй хайрцаг, цэвэрлэгээний материал, нормын хувцас, зөөлөн эдлэл, бичиг хэргийн материал худалдан авах тендерийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт хийж, 198,000.0 мянган төгрөгийн төсөвтэй байснаас 10 компанитай 187,837.2 мянган төгрөгийн гэрээ,
- Хүнсний материал худалдан авах нээлттэй тендер шалгаруулалтыг 607,800.0 мянган төгрөгийн дүнтэй 5 багцад зарлаж, 2 компанитай 575,800.0 мянган төгрөгийн гэрээ,
- Шатахуун худалдан авах 49.100.0 мянган төгрөгийн төсөвтэй тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулж, 1 компанитай 43.400.0 мянган төгрөгийн гэрээ тус тус байгуулсан байна.
- Эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж, цус цусан бүтээгдэхүүн худалдан авалтаар нийт 4,736,530.0 мянган төгрөгийн 85 багц бүхий цахим тендер шалгаруулалтыг зохион байгуулж, нээлттэй тендер шалгаруулалтын үр дүнд 57 багцад 3,252,648.4 мянган төгрөгийн гэрээг 24 байгууллагатай, хязгаарлагдмал тендер шалгаруулалтын үр дүнд 20 багцад 972,486.3 мянган төгрөгийн гэрээг 9 байгууллагатай, харьцуулалтын аргаар 8 багцад 9 байгууллагатай 312,733.5 мянган төгрөгийн гэрээг байгуулсан байна.
- 56 багц бүхий нийт 10,810,887.0 мянган төгрөгийг өндөр өртөгт мэс засалд хэрэглэгдэх хэрэгсэл худалдан авах нээлттэй цахим тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 53 багцад 10,221,294.0 мянган төгрөгийн гэрээг 16 тендерт оролцогч байгууллагатай гэрээг тус тус байгуулан ажиллаж байна.

Тендерийн гэрээний хугацаа 2022 оны 3, 4 дүгээр сард дуусна.

Төсвийн хөрөнгөөр 6,287,593.7 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар 505,867.6 мянган төгрөгийн хувийн хамгаалах хэрэгсэл, эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодисыг үнэ төлбөргүй хүлээн авснаас коронавирус /Ковид-19/-тай холбоотойгоор 1,044, 790.8 мянган төгрөгийг зохих журмын дагуу зарцуулжээ.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/237 дугаар тушаалаар 538,200.0 мянган төгрөгийн эрх шилжин ирж, сонгон шалгаруулалтын эрхийг Гэмтэл согог судлалын үндэсний төвд, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, захиалагчийн хяналт тавих эрхийг Эрүүл мэндийн яаманд хариуцуулсан байна.

Тушаалын дагуу Гэмтэл согог судлалын үндэсний төвийн “Дээвэр болон Түлэнхийн тасгийн их засварын ажил” №ЭМЯ/202104069 тоот нээлттэй тендерийг зарлан сонгон шалгаруулалт явуулж, Багц-1 /Түлэнхийн тасгийн засварын ажил/-д “Энгүүн Очир Констракшн” ХХК-тай 293,133.2 мянган төгрөгийн, Багц-2 /Дээврийн засварын ажил/-д “Бако констракшн” ХХК-тай 198,190.5 мянган төгрөгийн, Багц-3 /Дотор талын цэвэр усны шугам засвар/-ын ажилд “Хайрхан бар” ХХК-тай 22,957.9 мянган төгрөгийн гэрээ байгуулах зөвлөмжийг ЭМЯ-нд хүргүүлж, 2021 оны 7 дугаар сарын 5-ны өдөр гэрээ байгуулсан байна.

Дээврийн засварын ажил болон Шугам засварын ажлууд 2021 оны 10 дугаар сарын 1-ний дотор хийгдэж, компаниуд холбогдох бичиг баримтуудыг Барилга хөгжлийн төвд хүргүүлсэн боловч Улсын комисс ажиллаагүй байна.

Гэмтэл согог судлалын үндэсний төв нь Түлэнхийн тасгийг ковидын үеийн эмчилгээний тасаг болгож түр ажиллуулсан тул засварын ажил хойшлогдож, 2022 оны 1 дүгээр сард дууссан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төсвийн, ТБОНӨХБАҮХАТХ-ийн болон бусад холбогдох хууль эрхийн актын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,000.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 22,796.5 мянган төгрөгийн 3 албан шаардлагыг биелүүлж, 656,333.4 мянган төгрөгийн 6 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2,000.0	1	2,000.0	0	0	100.0
Албан шаардлага	3	22,796.5	3	22,796.5	0	0	100.0
Зөвлөмж	6	656,333.4	6	656,333.4	0	0	100.0
Нийт дүн	10	697,129.9	10	697,129.9	0	0	100.0

Завсрын аудитаар 3,556,982.7 мянган төгрөгийн 14 алдаа, зөрчилд өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад алдаа зөрчлийг бүрэн залруулсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ЭМД-ын сангаас нэхэмжилсэн болон гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зөрүүгийн асуудлыг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,083,677.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,058,961.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 24,716.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн тогтоосон материаллаг байдлын түвшин 422,781.6 мянган төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- 2021 оны эхний үлдэгдэл 40,000.0 мянган төгрөгийн авлагыг хааж зардалд бичсэнийг,
- Санхүүгийн байдлын тайлан, үндсэн хөрөнгийн тодруулга дахь хуримтлагдсан элэгдлийн болон үлдэгдэл өртгийн дүн Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй дэх дүнгээс 944,743.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэнийг,
- Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь үндсэн үйл ажиллагааны орлого 953.0 мянган, эмийн зардал 3,853.6 мянга, цалингийн зардал 17,385.6 мянган төгрөгөөр тус тус ерөнхий журналын дүнгээс дутуу тусгагдсаныг,
- Үндсэн үйл ажиллагааны орлогод туслах үйл ажиллагааны 52,026.1 мянган төгрөгийн орлого бүртгэснийг тус тус залруулга хийлгэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хууль зүйн туслалцаа авах гэрээ байгуулан, хуулийн зөвлөгөө, өмгөөллийн хөлсөнд 13,100.0 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалттай нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хууль зүйн туслалцаа, хуулийн зөвлөгөөг төрийн мэргэжлийн байгууллагад хандаж байх, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын дансаар дамжуулалгүй 10,116.2 мянган төгрөгийг зардалд шууд бичсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-тай нийцэхгүй, "Ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Мөнгөн хөрөнгийн зарлагыг тооцооны дансаар дамжуулдаг байх, Төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны зааврыг мөрдөн ажиллах, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3. Орлого данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу үндсэн үйл ажиллагааны орлогын бичилтийн алдааг залруулсан боловч 2021 оны 12 дугаар сарын 29-30-ны орлогыг багцлан бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” заалттай нийцэхгүй, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орлогыг хуримтлуулан бүртгэхгүй, орлого орсон тухай бүр данс бүртгэлд тусгадаг байх, анхан шатны баримтыг үндэслэн гүйлгээг гарсан тухай бүрд нь бүртгэж, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх.

4. Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ТӨБЗГ-аас ашиглах жил, үнэ шинэчлэн тогтоох зөвшөөрөл авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

5. Дотоод хяналт шалгалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ерөнхий захирлын 2021 оны 5 дугаар сарын 10-ны А/65, 9 дүгээр сарын 1-ний А/112 дугаар тушаалуудаар хяналт шалгалтын удирдамж тус тус батлагдсан боловч хяналт шалгалт хийгдсэн эсэх нь тодорхойгүй байна. Энэ нь Гэмтэл согог судлалын үндэсний төвийн “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-тай нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтны орон тоонд тухайн ажлын байрны шалгуурт нийцэх ажилтныг томилон ажиллуулж, тус байгууллагын стратеги зорилтыг хангахад дэмжлэг үзүүлэх дотоод хяналт шалгалт хийж байх.

Илрүүлэлт:

Хувийн аудитын хуулийн этгээдээр дотоод аудит хийлгүүлж, 1,500.0 мянган төгрөгийн төлбөр төлсөн нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг үр дүнтэй зарцуулж дотоод хяналтыг сайжруулж, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
							тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
/мянган төгрөгөөр/																
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	ГССҮТ	АХГ-2022/365/НА-СТА-ТШ326	2021 оны эхний үлдэгдэл авлагыг хааж зардалд бичсэн.	СБТайланд авлагын эцсийн үлдэгдэл залруулсан	1	40,000.0	1	40,000.0								
2	ГССҮТ	АХГ-2022/365/НА-СТА-ТШ327	Санхүүгийн байдлын тайлан, үндсэн хөрөнгийн тодруулга дахь хуримтлагдсан элэгдлийн болон үлдэгдэл өртгийн дүн Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй дэх дүнгээс дутуу илэрхийлэгдсэн	СБТайланд хуримтлагдсан элэгдэл болон үлдэгдэл өртгийн дүнг залруулсан	1	944,743.0	1	944,743.0								
3	ГССҮТ	АХГ-2022/365/НА-СТА-ТШ328	Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь үндсэн үйл ажиллагааны орлого, эмийн зардал, цалингийн зардал ерөнхий журналын дүнгээс дутуу тусгагдсан.	СҮДТайланд орлого, зардлын дүнг залруулсан	1	22,192.3	1	22,192.3								
4	ГССҮТ	АХГ-2022/365/НА-СТА-ТШ329	Хууль зүйн туслалцаа авах гэрээ байгуулан, хуулийн зөвлөгөө, өмгөөллийн хөлс төлсөн.	Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх.	1	13,100.0								1	13,100.0	
5	ГССҮТ	АХГ-2022/365/НА-СТА-ТШ330	Хувийн аудитын компаниар дотоод аудит хийлгүүлж, төлбөр төлсөн.	Байгууллагын дотоод хяналтыг сайжруулж, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулж, ажиллах албан шаардлага өгөх	1	1,500.0								1	1,500.0	
6	ГССҮТ	АХГ-2022/365/НА-СТА-ТШ331	Үндсэн үйл ажиллагааны орлогод туслах үйл ажиллагааны орлого бүртгэсэн.	СҮДТайланд орлогын дүнг залруулсан	1	52,026.1	1	52,026.1								
7	ГССҮТ	АХГ-2022/365/НА-СТА-ТШ332	Бараа материалын дансаар дамжуулалгүй зардалд шууд бичсэн.	Төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны зааврыг мөрдөн ажиллах, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх.	1	10,116.2								1	10,116.2	

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

7	ГССҮТ	АХГ-2022/365/НА-СТА-ТШ333	Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу үндсэн үйл ажиллагааны орлогын бичилтийн алдааг залруулсан боловч нийт залруулгыг 2021 оны 12 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд багцлан бүртгэсэн.	Анхан шатны баримтыг үндэслэн гүйлгээг гарсан тухай бүрд нь бүртгэж, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх.	1	-									1	
7	ГССҮТ	АХГ-2022/365/НА-СТА-ТШ334	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 174 нэрийн 1,745,818.2 мянган төгрөгийн хөрөнгө ашиглагдаж байна.	ТӨБЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоох, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	-									1	-
7	ГССҮТ	АХГ-2022/365/НА-СТА-ТШ335	Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Ерөнхий захирлын 2021 оны 5 дугаар сарын 10-ны А/65, 9 дүгээр сарын 1-ний А/112 дугаар тушаалуудаар хяналт шалгалтын удирдамж тус тус батлагдсан боловч хяналт шалгалт хийгдсэн эсэх нь тодорхойгүй байна.	Дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтны орон тоонд тухайн ажлын байрны шалгуурт нийцэх ажилтныг томилон ажиллуулж, тус байгууллагын стратеги зорилтыг хангахад дэмжлэг үзүүлэх дотоод хяналт шалгалт хийж байх	1										1	-
Санхүүгийн тайлангийн аудитын дүн					10	1,083,677.6	4	1,058,961.4	-	-					6	24,716.2
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
Нийцлийн аудитын дүн					-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн					10	1,083,677.6	4	1,058,961.4	-	-	-	-	-	-	6	24,716.2

